

“РЕСУРСПАРТНЕРС ГРУПП” ХХК



ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ТАЙЛАН

РД: 5556554

УЛААНБААТАР ХОТ 2024 ОН

ГАРЧИГ

ГАРЧИГ	1
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	1
ОРШИЛ.....	2
I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
III ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	9
V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	16
V.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
V.4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлт	19
V.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	19
V.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	19
V.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	19
V.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
V.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	23
V.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	28
V.11 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....	29
V.12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	31
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга	3
Хүснэгт 2.	Уурхайн солбилцол	4
Хүснэгт 3.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн үр дүн.....	12
Хүснэгт 4.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт 5.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	19
Хүснэгт 6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	22
Хүснэгт 7.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	24
Хүснэгт 8.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
Хүснэгт 9.	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	30
Хүснэгт 10.	Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал	31

ОРШИЛ

“Ресурспартнерс групп” ХХК-ийн барилгын чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ –нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээний төлөвлөгөөт ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 16.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Үйл ажиллагааны хүрээнд уурхайн бэлтгэл ажлууд, ХАБ-ын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, Батноров сумын ЗДТГ-тай байгуулсан нийгмийн хариуцлагын ажлуудыг хийхээс гадна байгаль орчны болон хүний эрүүл мэндийг хамгаалах, уурхайн бүс нутгийн оршин суугчид руу чиглэсэн нийгмийн сайн сайхны төлөө ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. БОМТ-ний биелэлтийг нийт 38.4 сая төгрөгний зардал бүхий ажил төлөвлөсний 6.5 хувь нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулагдсан.

Уурхайн 2024 онд хэрэгжүүлсэн БОМТ биелэлтийн тайланг боловсруулахад байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “ТӨГРӨГ БАЯН ХАНГАЙ” ХХК-аас мэргэжлийн зөвлөгөө авсан бөгөөд төлөвлөгөөг БОАЖЯ-наас 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд төлөвлөлтийг тус журмын 1 дугаар хавсралтын “А”-д заасан агуулгаар боловсруулсан болно.

БОМТ-г нийт 12 бүлэг, 13 дэд бүлэгт багтаан 10 хүснэгт, 20 зураг, загварчилал болон тооцооллыг нотлох 20 хавсралтаар баримтжуулсан.

“РЕСУРСПАРТНЕРС ГРУПП” ХХК

I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөвлөгөөний нэр: “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Ресурспартнерс групп” ХХК

Төслийн зорилго: “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын хүдрийг олборлож, бутлан ангилан, сайн чанарын жоншыг зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Ресурспартнерс групп” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011328128	
3	Уурхайн нэр	Хавтгай-III	
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Хэнтий
5		Сум/Дүүрэг	Батноров
6	Ашигт малтмалын төрөл	Хүдэр	
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-021578	
8	Ашиглалт эхэлсэн огноо	2024	
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Чингэлтэй
11		Баг/Хороо	6-р хороо
12		Гудамж/Байр	Лааганы гудамж, 63А байр 01 тоот
13		Гар утас	99082810
14	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Д.Даяндэмэд
15		Гар утас	99082810
16		Электрон шуудан	dalaidayanaa@yahoo.com

Төслийн байршил: “Хавтгай -III” хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт байрладаг.

- Засаг захиргаа: Хэнтий аймаг, Батноров сум,
- Ордын нэр: "Хавтгай-III хайлуур жоншны орд"
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Хайлуур жонш
- Трапедийн номенклатур: М-4-139
- Талбайн нийт хэмжээ: 633.58 га

Хүснэгт 2. Уурхайн солбилцол

№	Газарзүйн солбицол					
	Уртраг			Өргөрөг		
1	111	27	1.88	48	5	51
2	111	27	1.88	48	6	51.85
3	111	28	31.87	48	6	51.85
4	111	28	31.87	48	7	51.82
5	111	27	1.88	48	7	51.82
6	111	27	1.88	48	7	1.81
7	111	25	41.87	48	7	1.81
8	111	25	41.87	48	6	36.04
9	111	26	7.18	48	6	35.76
10	111	26	7.18	48	5	51



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл “Ресурспартнерс групп” ХХК-д 633.58 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-021578 дугаар бүхий гэрчилгээг 2020 оны 04 сарын 21-ний өдөр олгосон байна.

Уурхайн одоогийн байдал: “Ресурспартнерс групп” ХХК нь Хавтгай-III хайлуур жоншны ордыг ашиглах ТЭЗҮ-ийг 2024 онд батлуулсан бөгөөд түүнээс хойш үйл ажиллагаа явуулж байна.

Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц:

Ил уурхайн С зэрэглэлийн нөөцөд тулгуурлаж хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг магадалсан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадалсан В' үйлдвэрлэлийн нөөц нь 294.12 мян.тн хүдэр байна. Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр $6.92 \text{ м}^3/\text{м}^3$ буюу $2.55 \text{ м}^3/\text{тн}$ болж байна.

Төслийн хүчин чадал: 2024 оны төлөвлөгөөгөөр бүрэн хүчин чадлаараа буюу 193.0 мян.тонн хүчин чадалтай ажиллана. Орд нь эхний жилд 153 хоног хоёр дахь жилд 275 хоног ажиллана. Уурхайн үйл ажиллагаа нь хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Тэсэлгээний ажил: Тэсэлгээний ажилд дотоодод үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO” найрлагат тэсрэх бодис, мөн эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээг **10 хоногт нэг удаа** хийх ба тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу аюулгүй байдлыг дээд зэргээр хангасны үндсэн дээр өрөмдлөг-тэсэлгээний ажлыг мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээлэн гүйцэтгүүлнэ.

II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ландшафт: “Хавтгай-III хайлуур жоншны орд” нь ландшафтын мужлалаар Онон улз голын сав газрын хөмбөн-цулдам нам уул, хотгор, суурьт тал бүхий хээр, хуурай хээрийн мужид багтана. Төслийн талбай орчим нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Хангай-Хэнтийн уулархаг их мужид харьяалагдана.

Уур амьсгал, агаарын чанар: Бүх талаараа Азийн өндөр уулсаар хүрээлэгдэж далай тэнгисээс ихээхэн алслагдсан, гипсометрийн өндөр байрлалд оршдог тул тэнгисийн чийглэг салхи нэвтрэх боломж тун бага байдаг онцлогтой. Цаг уурын энэ онцлог нь дүүргийг эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын болон хоногийн халуун хүйтний хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй болгодог.

Өвөлдөө олон жилийн дундаж температур -20 аас, -35°C хэм хүрч, дулаан нь 7-р сард 25 аас 30.9°C хүрнэ. Жилд унах хур тундасны дундаж хэмжээ 200-300 мм тунадас унана, Харьцангуй чийглэг уур амьсгалтай ба харьцангуй дундаж чийгшилт 35% байна. Салхины хурд өвөлдөө 1.8-2 м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-30 см орчим байдаг.

Усан орчин: Усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын сумаар, Эхэнбүрд, Дундбүрд, Адагбүрд, Бургаст зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг.

Ордын сумын талбайд байгаа томоохон амууд, гуу жалга нь баруун, баруун хойш чиглэлтэй юм. Тэдгээрийн ихэнх нь эхэндээ бага зэргийн ундаргатай, булгуудтай, зарим нь түр зуурын урсгалтай жижиг горхиуд байдаг. Цас борооны усаар тэжээгддэг эдгээр горхиуд нь адаг руугаа шургаж тасардаг ба зарим нэг нь Бүхэг, Түргэний голд цутгадаг.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод бүхий нутаг хамрагдах бөгөөд талбайд тархсан хөрсний хувьд зонхилох хэв шинж нь уулын хар хүрэн хөрс, толгод болон нам уулсын хажуугаар чулуурхаг нимгэн хар шороон хөрс.

Ургамлан нөмрөг: Ойт хээрийн ба хээрийн бүсийн өвслөг, цэцэгт ургамал, газар зүйн бүх төрлийг хамаарах бөгөөд хадлан, бэлчээр газар тариалангийн талбайн хувьд дунд зэрэг төлөвтэй.

Амьтан: Тарвага, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, шилүүс, мануул, дорго, туулай, чандага, өмхий хүрэн, зурам зэрэг ан гөрөөс элбэг байх ба буга, зэрлэг гахай нилээд байдаг байсан ч ховордсон. Хэрлэн мөрөнд соом, булуу цагаан, зэвгэ, цурхай загас байх ба зарим үед тул загас үзэгддэг.

Түүх соёлын дурсгалд газрууд: Үйл ажиллагаа явуулах төслийн талбайд түүх соёлын дурсгалт газрууд илрээгүй.

Хэнтий аймгийн Батноров сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Засаг захиргааны нэгжийн хувьд сум нь Эрдэнэчандмань, Эхэнбүрд, Баян, Баянбулаг, Идэрмэг, Дундбүрд, Бэрх гэсэн 7 багтай.

2023 оны жилийн эцсийн байдлаар Батноров суманд нийт 5689 хүн ам оршин сууж байна. Үүнээс 2913 нь эрэгтэй, 2776 нь эмэгтэй эзэлж байна. Өөрөөр хэлбэл Батноров сумын нийд иргэдийн 48.8% нь эмэгтэй, 51.2% нь эрэгтэй эзлэж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1773 өрх бүртгэгдсэнээс 466 өрх буюу 61.3%-ийг 1 ам бүлтэй өрх эзлэж байна. Нийт өрхийн 845 нь малчин өрх байна. Мал сүрэг нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 328.7 мянган толгой мал үүнээс Тэмээ 0.2 мян.толгой, Адуу 32.7 мян.толгой, Үхэр 26.8 мян.толгой, Хонь 175.0 мян.толгой, Ямаа 93.9 мян.толгой мал тус тус тоолуулсан байна. (эх сурвалж: “Хэнтий аймгийн статистикийн эмхэтгэл 2023”, 2024 он)

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн төрийн 6 байгууллагатай. Хувийн хэвшлийн 72 аж ахуй нэгж, иргэн арьс шир боловсруулах, хүнсний дэлгүүр, талх гурилан боовны цех, цагаан идээ боловсруулах, гар урлал, үсчин гоо сайхан зэрэг жижиг дунд үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Томоохон уул уурхай Алтан гадас одонт Бэрхийн уурхай, Ямаатын уурхай, Хавтгайн уурхай, Чимэдийн уурхай, Баяжуулах үйлдвэр гэсэн байгалийн баялаг жонш үйлдвэрлэх, боловсруулах уурхай, үйлдвэрүүдтэй. Эдийн засгийн чадамжийн хувьд Бэрхээс тусдаа төсөвтэй явдаг бөгөөд сумын нийт төсөв нь жилийн 3.2 тэрбум.төгрөг, үүнээс сумын өөрийн татварын орлого 0.2 хувийг нь бүрдүүлэн төвлөрүүлдэг.

Ш ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, гадаад болон дотоод овоолго, бутлах үйлдвэр, ажилтнуудын түр амьдрах байр зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх, бутлуурт орж буй чулуулаг дахь тоос агаарт дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Гадаргын болон газрын доорх усны нөөцөд нөлөөлөх нөлөөлөл бага байна.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдахаар байна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй.

Эерэг нөлөөллийн хувьд амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны хотын тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл: “Ресурспартнерс групп” ХХК–ний ашиглалтын талбайн ойр орчимд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс, түүнтэй холбоотой эд өлгийн зүйлс илрээгүй байна.

Олборлолтын явцад түүх эд өлгийн олдвор олдсон тохиолдолд холбогдох Төрийн байгууллагад мэдэгдэн хамтран ажиллах шаардлагатай.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Улсад болон орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, ажлын байр нэмэгдүүлэх, нийслэл хотын барилга зам гүүрийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг түүхий эдээр хангах зэрэг эерэг нөлөөлөл байна.

Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл: Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах,

шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-ний тайланг боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлт тайлан:

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулсан арилгах арга хэмжээнүүдийн биелэлт
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээний биелэлт, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлт тайлан:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БОМТ биелэлтийн тайлангийн бүтэц: БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн гол зорилт, хамрах хүрээ


6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт
7. Дүгнэлт


V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт


Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн үр дүн

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн үр дүн
1	2	3	4	5	
Газрын гадаргуу хөрсөнд үзүүлэх нөлөөлөл					
1	Хөрс хуулалт, хөрсний овоолгоос газрын гадаргын хэлбэр төрх өөрчлөгдөх, эвдрэх	Ил уурхайн талбайн хэмжээнээс хэтэрч ажиллахгүй байх			Шав тэмдэгжүүлэх ажилд хийгдсэн бөгөөд батлагдсан нөөцийн блокийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.
2	Уул уурхайн үйл ажиллагаанаас өнгөн хөрс эвдрэх, доройтох	Үржил шимт хөрсийн стандартын дагуу хуулах, овоолго хийх		ТНС-н зардалд орсон.	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хуулж эхний бэлтгэл ажлыг хийж байна. 
3	Хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх	Үйлдвэрлэлийн технологийн замын зураг гаргаж зөвхөн заасан замаар машин техникүүдийг зорчуулах, Лицензийн талбай доторх замыг тэмдэгжүүлэх		500,000.0	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5
					

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5
4	Машин техникийн засвар үйлчилгээ бусад үйл ажиллагаанаас хөрс бохирдуулах	Засвар үйлчилгээ хийхэд хөрсийг нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх нөхцөл бүрдүүлэх асгаралтын иж бүрдэл байршуулах,	-	2,000,000.0	
5	Хөрс доройтох, цөлжих эсэх	Эвдрэлд орсон талбайд биологийн нөхөн сэргээлт хийх,	Уурхайн талбайд	БНС-н зардалд орсон.	Төслийн ТЭЗҮ болон БОННУ-д тусгасны дагуу олборлолт хийж дууссаны дараа 3 дахь жилээс нөхөн сэргээлтийн ажил хийгдэх тул 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус төсөлд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөөгүй болно.
6	Хөрсний бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөх	Уулын ажлыг зөвхөн уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Уурхайн талбайд	-	Төлөвлөгөөний дагуу хийгдээд явж байна.
7	Зам дагуу хөрс эвдэрч, тоос тархах	Зам арчилгааны зардал	Уурхайн замд	Эвдрэл гарсан тохиолдолд ҮА-ны зардлаар	Уурхайн тээврийн замыг сайжруулан хайрга дэвсэж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5
					
Ургамлын төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл					
8	Ургамлын бүтэц бүрэлдэхүүнд нөлөөлөх эсэх	Эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийх,	Уурхайн талбайд үйл ажиллагаа дуусахад	БНС-н зардалд орсон	Төслийн ТЭЗҮ болон БОННУ-д тусгасны дагуу олборлолт хийж дууссаны дараа 3 дахь жилээс нөхөн сэргээлтийн ажил хийгдэх тул 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус төсөлд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөөгүй болно.
9	Ургамлын биомассд нөлөөлөх эсэх	Тоос үүсэх талбайг услах	Уурхайн зам-0.74 га	Усалгааны зардалд орсон	Уурхайн тээврийн замыг сайжруулан хайрга дэвсэж байна. Уурхайн замын бэлтгэл ажлын дараа усалгааны ажлыг эхлүүлнэ.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5
					
Бусад					
10	Байгалийн үзэсгэлэнт төрх	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр орон нутгийн удирдлагын заасан газар мод, бут, сөөг тарих	Жилд 1 удаа	Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөний зардалд орсон	БОННУ-ээр жилд 200 ш мод тарихаар төлөвлөсөн боловч 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувьд мод тарих хугацаа өнгөрсөн (намрын мод тарих сүүлийн хугацаа 10 сарын 20-оос өмнө хийгддэг) тул төлөвлөөгүй болно.
Нийт зардал				2,500,000.0	

V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Төслийн ТЭЗҮ болон БОННУ-д тусгасны дагуу олборлолт хийж дууссаны дараа 3 дахь жилээс нөхөн сэргээлтийн ажил хийгдэх тул 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус төсөлд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөөгүй болно.

V.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хэнтий аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2024 оны 10 сарын 18-ы өдрийн 408 дугаар албан бичгийн дагуу “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”-ий дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд “Хар ямаат”-ын байгалийн нөөц газрын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах саналыг хүргүүлсэн. Үүнд:



-Махчин шувуунд суух суулт хийсэн;

-Өвөлжилт хүндэрсэн үед зэрлэг амьтанд хужир, мараа, өвс тавих арга хэмжээ зохион байгуулсан;

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5
1.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Махчин шувуунд суух суулт хийх	-	5 ш	25 ширхэг суулт хийж өгч орон нутагтай ажил хүлээлцэх акт үйлдсэн.
2.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Өвөлжилт хүндэрсэн үед зэрлэг амьтанд хужир, мараа, өвс тавих арга хэмжээ зохион байгуулах	-		16 ширхэг шуудай буюу 1 тн хужир “Хар ямаат” БЦГ-т тавьж орон нутагтай ажил хүлээлцэх акт үйлдсэн.

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ТАЙЛАН**

	НХМаягт БМ-3 Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт	<p align="center">ЗАРЛАГЫН БАРИМТ № _____</p> <p align="center"><u>Зам зуур</u> (байгууллагын нэр) <u>Ресурс партнерс үүднэ</u> (худалдан авагчийн нэр)</p> Регистрийн № <u>С14700107</u> Регистрийн № <u>БГРБ 557</u>	<p align="center">РЕСУРСПАРТНЕРС ГРУПП ХХК-НЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГИЙН ХҮРЭЭНД БАЯН-ОВОО СУМЫН ХАР ЯМААТ БНГАЗАРТ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АЖЛЫН АКТ</p> <p align="center">2024.12.09</p> <p>Тус сумын Дэлгэрхаан багийн нутаг Хар Ямаат БНГазарт Ресурспартнерс групп ххк-ны нийгмийн хариуцлагын хүрээнд шувууны суутуур 25ш, хужир 16 шуудай буюу 1тн хүлээлгэн өгөв. Уг ажлыг Байгаль хамгаалагч Ш.Эрдэнэбая, Хар Ямаат БНГазрын Байгаль хамгаалагч Г.Пүрэвсүх, нярав Г.Батсайхан, Үйлчлэгч Ж.Хэрлэнцацаг нар хүлээн авч ажилласан. Цаашид өвөлжилт хүндэрсэн үед Хар ямаат БНГазрын зэрлэг ан амьтад биотехникийн аргаар тарааж тавихаар тохиролцов.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p align="center">ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН: РЕСУРСПАРТНЕРС ГРУПП ХХК МЕНЕЖЕР <u>О.Х.СҮХБАТ</u> ХҮЛЭЭН АВСАН: ЗДТГАЗРЫН ДАРГА <u>О.ОЮУНЧИМЭГ</u> БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ <u>Ш.ЭРДЭНЭЗАЯА</u></p> <div style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block; text-align: center;"> СДА0002 О.ОЮУНЧИМЭГ ЗДТГАЗРЫН ДАРГА </div>																																																																																																																																																						
	20 <u>24</u> оны <u>12</u> сарын <u>09</u> өдөр (тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)	<table border="1" style="width:100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар</th> <th rowspan="2">Код</th> <th rowspan="2">Хэмжих нэгж</th> <th colspan="3">Худалдах</th> </tr> <tr> <th>Тоо</th> <th>Нэгжийн үнэ</th> <th>Нийт дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td><u>Хужир 248с</u></td> <td></td> <td><u>кг</u></td> <td><u>1000</u></td> <td><u>1000</u></td> <td><u>1.000.000</u></td> </tr> <tr><td>2</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>3</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>4</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>5</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>6</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>7</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>8</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>9</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>10</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>11</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>12</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>13</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>14</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>15</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>16</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>17</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>18</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>19</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td><u>1.000.000</u></td></tr> <tr><td>20</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table>	№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэмжих нэгж	Худалдах			Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн	1	<u>Хужир 248с</u>		<u>кг</u>	<u>1000</u>	<u>1000</u>	<u>1.000.000</u>	2							3							4							5							6							7							8							9							10							11							12							13							14							15							16							17							18							19						<u>1.000.000</u>	20							Дүн <u>ЦЭЦЭГМАА ОВОГОТ</u> ЧИНЗОРИН Хүлээлгэн өгсөн эд хариуцагч: _____ Хүлээн авагч _____ Шалгасан нягтлан бодогч _____
№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код					Хэмжих нэгж	Худалдах																																																																																																																																																	
			Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн																																																																																																																																																				
1	<u>Хужир 248с</u>		<u>кг</u>	<u>1000</u>	<u>1000</u>	<u>1.000.000</u>																																																																																																																																																			
2																																																																																																																																																									
3																																																																																																																																																									
4																																																																																																																																																									
5																																																																																																																																																									
6																																																																																																																																																									
7																																																																																																																																																									
8																																																																																																																																																									
9																																																																																																																																																									
10																																																																																																																																																									
11																																																																																																																																																									
12																																																																																																																																																									
13																																																																																																																																																									
14																																																																																																																																																									
15																																																																																																																																																									
16																																																																																																																																																									
17																																																																																																																																																									
18																																																																																																																																																									
19						<u>1.000.000</u>																																																																																																																																																			
20																																																																																																																																																									
Нийт		10,000,000.0																																																																																																																																																							

V.4 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлт

БОННУ-ээр жилд 200 ш мод тарихаар төлөвлөсөн боловч 2024 оны байгаль орчны менежиентийн төлөвлөгөөний хувьд мод тарих хугацаа өнгөрсөн (намрын мод тарих сүүлийн хугацаа 10 сарын 20-оос өмнө хийгддэг) тул төлөвлөөгүй болно.

V.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй.

V.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хайлуур жоншны ордын эзэмшлийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгуулагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай.

V.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4
1	Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Засвар техникийн хэлтэсийн баг хамт олон байнга шалгаж, тогтмол аюулгүй байдлыг хангуулж байна.



	<p>сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх</p>			
2		<p>Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах</p>	<p>Уурхайн ажилчид</p>	<p>ХАБЭА сургалтын хүрээнд ХАБ инженер зохион байгуулсан</p> 


3		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайд	
4		Уурхайн цогцолборын эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах	Далан байгуулах	
Нийт			10,000,000.0	

V.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

“Ресурспартнерс групп” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллаж байна.

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлтийн үр дүн
1	1	2	3	4
1	Ахуйн	Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Уурхайн ажилчид	Хог хаягдлын гэрээ байгуулсан хавсралтаар оруулав.
2		Ахуйн хатуу хог хаягдал хаях сав байрлуулах	Уурхайн талбайд	 

3		Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих	Хог хаягдлын цэгт	
Нийт			3,500,000.0	

V.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Ресурспартнерс групп” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.


Уг ордын үйл ажиллагааны явцад БОННУ-ий тайлан, БОХТ-д тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Ресурспартнерс групп” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам)-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналтын шинжилгээний үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хяналтын шинжилгээний ажлын хэмжээ	Зардал /мян.төг/ 1 дэх жил	Биелэлтийн үр дүн
1	2	3	4	5	6	
Агаарын орчин						
1	Дуу чимээ	Уурхай		Үйл ажиллагааны туршид	30,000.0	“Төгрөг баян хангай” ХХК- Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Төслийн эзэмшил талбайд агаарын чанарын хяналтын 4 цэгээс авсан дуу чимээний хэмжилтийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй үзүүлэлттэй байна.
Хөрс						
2	Механик бүрэлдэхүүн	%	Уурхайн ухаш Хөрсний овоолго Хотхоны орчим Зам	Намар 1 удаа	58,500.0	Тус нэгж талбарт хар шороон хөрс тархсан гэж үзэж 4 дээж авч, агро хими, эрүүл ахуй, хүнд металлыг тус тус шинжлүүлсэн. Химийн шинжилгээний үр дүнгээр хөрсний А үе нь сул шүлтлэг урвалын орчинтой, АВ үе нь дунд шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж маш бага, хялбар уусах давсны агууламж бага, цахилгаан дамжуулах чадвар бага, карбонатын агууламж бага, нийт нитрат азотын хангамж маш бага, солилцох сууриас Са хангалттай, Mg маш их агууламжтай, хөдөлгөөнт фосфор бага, калийн агууламж маш бага байна. Хөрсний үржил шимийн түвшин бага байна. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад хөрс бага бохирдолтой байна.
3	Ялзмагт үеийн зузаан	см				
4	Ялзмаг	%				
5	Карбо нат	%				
6	Нефтийн бүтээгдэхүүний агууламж	мг/100 гр				
7	Хүнд элементийн бохирдол	мг/100 гр	Хөрсний овоолго Зам	Намар 1 удаа	42,000.0	
8	Бусад бохирдлын үзүүлэлтүүд	мг/100 гр	Хотхоны орчим	Намар 1 удаа	24,000.0	

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ТАЙЛАН



“НАРТ ШҮҮН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖ, ТЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
лүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com



Захиалгач: “Эко экспрес” ХХК
Дэж авсан цэг: “Ресурс партнерс групп” ХХК, Хэнтий аймаг, Батноров сум MV-021578
Сорьц авсан огноо: 2024 оны 09 сар 19 өдөр
Шивжилтээ хийсэн огноо: 09 сарын 26
Харилцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дэж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солидох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ²⁺	Mg ²⁺	P ₂ O ₅	K ₂ O
Зүсэлт 1, 111 27 46.8, 48 07 46.92											
1	10-20	7.69	0.008	0.021	4.22	0.00	0.06	26	10	7.8	16
Зүсэлт 2, 111 28 4.8, 48 07 13.8											
2	10-30	6.85	0.006	0.015	3.16	0.00	0.04	26	5	7.3	12
Зүсэлт 3, 111 27 18, 48 07 17.76											
3	0-20	6.64	0.005	0.011	2.65	0.00	0.03	21	12	2.0	4
Зүсэлт 4, 111 27 21.98, 48 06 53.68											
4	0-30	6.76	0.008	0.018	3.65	0.00	0.06	27	11	11.2	22
Зүсэлт 5, 111 25 58.8, 48 06 48.96											
5	20-40	6.53	0.004	0.010	2.86	0.00	0.02	18	14	8.5	4
Зүсэлт 6, 111 26 27.6, 48 06 3.6											
6	0-20	6.40	0.005	0.012	3.12	0.00	0.03	22	11	14.9	4




2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дэж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
Зүсэлт 1, 111 27 46.8, 48 07 46.92								
1	10-20	2.2	50.3	21.3	11.3	6.2	8.7	26.2
Зүсэлт 2, 111 28 4.8, 48 07 13.8								
2	10-30	3.7	51.9	20.4	12.2	4.6	7.2	24.0
Зүсэлт 3, 111 27 18, 48 07 17.76								
3	0-20	4.9	50.4	19.4	12.7	6.2	6.4	25.3
Зүсэлт 4, 111 27 21.98, 48 06 53.68								
4	0-30	2.3	50.8	22.9	13.5	3.3	7.2	24.0
Зүсэлт 5, 111 25 58.8, 48 06 48.96								
5	20-40	2.9	53.3	20.5	13.6	3.9	5.8	23.3
Зүсэлт 6, 111 26 27.6, 48 06 3.6								
6	0-20	4.3	53.1	19.8	12.4	4.2	6.2	22.8

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ТАЙЛАН

№	Хяналтын шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хяналтын шинжилгээний ажлын хэмжээ	Зардал /мян.төг/ 1 дэх жил	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5	6
Ус						
9	Нийт хатуулаг	Н	Ундны усанд	1 ≤ эх үүсвэрээс Намар 1 удаа	46,000.0	Худгийн усны шинжилгээгээр химийн бүрэлдэхүүнээр гидрокарбонатын, холимог бүлгийн, чанарын хувьд 2-р бүлгийн
10	Хлорын ион /Cl/	Мг/л				
11	Сульфатын ион /SO4/	Мг/л				
12	Натрийн азот (NO ₂ ⁻)	Мг/л				
13	Нитрат азот (NO ₃)	Мг/л				
14	(CO ₃ ⁻)	Мг/л				
15	(HCO ₃ ⁻)	Мг/л				
16	Устөрөгчийн илтгэгч /PH/	Мг/л				
17	Үнэр	Чанарын үнэлгээгээр				
18	Амт	Чанарын үнэлгээгээр				
19	Өнгө	Чанарын үнэлгээгээр				

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ТАЙЛАН**

					<p align="center">ЦЭНГЭГДҮҮ, хатуувтар ус байна.</p> <div style="text-align: center;">  <p>ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ГАЗАРЗҮЙ ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ</p> <p>Усны химийн шинжилгээний тодорхойлолт</p> <p>Сорьц авсан: 2024 оны 09 сарын 20 өдөр Шинжилгээ хийсэн: 2024 оны 09 сарын 23 өдөр Сорьц авсан газрын нэр: Хэнтий аймаг, Батноров сум, 2-р баг</p> <p>Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Ресурс Партнерс Групп" ХХК</p> <p>Солбицол: X= 45° 1' 18.30" Y= 111° 29' 10.27" Гүн: м Ундарга: л/сек</p> <p>Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг</p> <table border="1" style="width:100%; border-collapse: collapse; text-align: center;"> <thead> <tr> <th rowspan="2">Анион</th> <th colspan="3">1дм³-д байгаа</th> <th rowspan="2">Катион</th> <th colspan="3">1дм³-д байгаа</th> </tr> <tr> <th>мг</th> <th>мг-экв</th> <th>мг-экв%</th> <th>мг</th> <th>мг-экв</th> <th>мг-экв%</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Cl⁻</td> <td>40.1</td> <td>1.13</td> <td>14.6</td> <td>Na⁺+K⁺</td> <td>44.0</td> <td>1.91</td> <td>24.8</td> </tr> <tr> <td>SO₄²⁻</td> <td>95.0</td> <td>1.98</td> <td>25.6</td> <td>Ca²⁺</td> <td>64.7</td> <td>3.23</td> <td>41.8</td> </tr> <tr> <td>NO₂⁻</td> <td>0.00</td> <td>0.00</td> <td>0.0</td> <td>Mg²⁺</td> <td>31.5</td> <td>2.59</td> <td>33.5</td> </tr> <tr> <td>NO₃⁻</td> <td>45.0</td> <td>0.73</td> <td>9.4</td> <td>NH₄⁺</td> <td>0.0</td> <td>0.00</td> <td>0.0</td> </tr> <tr> <td>CO₃²⁻</td> <td>0.0</td> <td>0.00</td> <td>0.0</td> <td>Fe²⁺</td> <td>0.0</td> <td>0.00</td> <td>0.0</td> </tr> <tr> <td>HCO₃⁻</td> <td>237.9</td> <td>3.90</td> <td>50.4</td> <td>Fe³⁺</td> <td>0.0</td> <td>0.00</td> <td>0.0</td> </tr> <tr> <td>Дүн</td> <td>418.0</td> <td>7.73</td> <td>100.0</td> <td>Дүн</td> <td>140.3</td> <td>7.73</td> <td>100.0</td> </tr> </tbody> </table> <p>HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 439.3 мг/дм³ Анион катионуудын нийлбэр: 558.3 мг/дм³</p> <p>Ерөнхий хатуулаг: 5.82 мг-экв/дм³ ЕС: 662 µS/cm pH: 7.86 TDS: 364 ppm</p> <p>Исэлдэх чанар: 1.44 мг/дм³ Физик шинж чанар</p> <p>Тунгалаг: 30 см Үнэр: үгүй Тунадас: Үгүй Өнгө: Өнгөгүй Амт: ***</p> <p align="center">HCO₃ 50 SO₄²⁻ 26 Cl 15 Усны найрлагын томъёо: Mg₂₄ Ca²⁺ 42 Mg²⁺ 34 Na⁺+K⁺ 25</p> <p align="center">Дүгнэлт</p> <p>Хөвийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатин ангийн, халимог бүртгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар ус байна. Шинжлэсэн хөвийн үлдсэн угуулалтуудээс магнийн ион нь "Учлын ус" зэрүүд ажлын шаардлага, чанар, аюулгүй байдалын үнэлгээ ИНИС0900:2018" стандартал зөвснөөс их байна.</p> <p>Мэч: Энэ үнэт үзэсгэл сорьц өвөг үй явцыг шинжлүүлсэн бөгөөд үзэсгэл хувь хүн зориулалтанд зориулагдсан болно.</p> <p>Гүйцэтгэсэн: Химич, ЭШДЭА:  Г.Үүрийнтуяа/ Шинжилгээ Хинэж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэлч  /Д.Гэрэлт-Од/</p> </div>	Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа			мг	мг-экв	мг-экв%	мг	мг-экв	мг-экв%	Cl ⁻	40.1	1.13	14.6	Na ⁺ +K ⁺	44.0	1.91	24.8	SO ₄ ²⁻	95.0	1.98	25.6	Ca ²⁺	64.7	3.23	41.8	NO ₂ ⁻	0.00	0.00	0.0	Mg ²⁺	31.5	2.59	33.5	NO ₃ ⁻	45.0	0.73	9.4	NH ₄ ⁺	0.0	0.00	0.0	CO ₃ ²⁻	0.0	0.00	0.0	Fe ²⁺	0.0	0.00	0.0	HCO ₃ ⁻	237.9	3.90	50.4	Fe ³⁺	0.0	0.00	0.0	Дүн	418.0	7.73	100.0	Дүн	140.3	7.73	100.0
Анион	1дм ³ -д байгаа			Катион	1дм ³ -д байгаа																																																																						
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%																																																																				
Cl ⁻	40.1	1.13	14.6	Na ⁺ +K ⁺	44.0	1.91	24.8																																																																				
SO ₄ ²⁻	95.0	1.98	25.6	Ca ²⁺	64.7	3.23	41.8																																																																				
NO ₂ ⁻	0.00	0.00	0.0	Mg ²⁺	31.5	2.59	33.5																																																																				
NO ₃ ⁻	45.0	0.73	9.4	NH ₄ ⁺	0.0	0.00	0.0																																																																				
CO ₃ ²⁻	0.0	0.00	0.0	Fe ²⁺	0.0	0.00	0.0																																																																				
HCO ₃ ⁻	237.9	3.90	50.4	Fe ³⁺	0.0	0.00	0.0																																																																				
Дүн	418.0	7.73	100.0	Дүн	140.3	7.73	100.0																																																																				
Нийт					2,400,000.0																																																																						

V.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Үйл ажиллагаандаа техник, технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Биелэлтийн үр дүн
1	2	3	4	5	
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн ажилчид	Дотоод зардал	Байнга	Дотоод журам гаргаж мөрдүүлж байна. Хавсралтаар оруулав.
2.	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Уурхайн ажилчид	500,000.0	Жил бүр	ХАБЭА сургалтын хүрээнд ХАБ инженер зохион байгуулсан 
